

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар нь Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны авто замаас 152 дугаар сургууль хүртэлх авто замын зураг төсөл (СХД, 26 дугаар хороо) боловсруулах ажлыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь **НХААГ/202210786** дугаартай болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ.

3.1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана.

3.2. Зам, тээврийн хөгжлийн яамнаас олгодог 2.8.1.4. Хотын авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах болон түүнээс дээш тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлнэ.

3.3. Сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-ийн аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна.

3.4. Сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-д хийж гүйцэтгэсэн ажлын жагсаалтыг хүснэгтээр ирүүлнэ. Сүүлийн 3 жил (2019, 2020, 2021 он)-ийн аль нэг жилд төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг доод тал нь нэг удаа хийж гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэсэн ажлын гэрээ, акт, захиалагчийн тодорхойлолтыг хавсаргана.

Авто зам, замын байгууламжийн ажлын зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх.

3.5. Голлох болон инженер техникийн ажилтнуудын дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ.

3.6. Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Мөн дараах тодорхойлолтуудыг “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх ба тендер нээсэн өдрийн байдлаар хүчин төгөлдөр байна. Үүнд:

3.6.1. Татварын ерөнхий газрын www.e-tax.mta.mn сайтыг ашиглан татварын цахим тодорхойлолт

(Хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ.)

3.6.2. Төрийн үйлчилгээний цахим (TYЦ) машинаас ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт

Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 15:00 цаг хүртэл авч болох бөгөөд мэдүүлгээ Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 15:30 цагийн дотор ирүүлнэ үү.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу-15,

Нийслэлийн Засаг захиргааны IV байр, 10 дугаар давхар,

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар,

Утас: 75757807

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn